

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ ГУРАВДУГААР САРЫН МЭДЭЭ

Нэг. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурал түүний ажлын хэсэг

Иргэд хөдөлмөрчидтэй хийсэн уулзалт: Сайншанд сумын 2,3,4,7-р багийн "Багийн иргэдийн нийтийн хурал" 03-р сарын 02-ны өдөр зохион байгуулагдаж, тус хуралд аймгийн ИТХ-ын дарга С.Түмэнбаяр, Сайншанд сумын ИТХ-ын дарга Д.Эрдэнэбаяр, Сайншанд сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч С.Одбаяр, баг тус бүрийн Засаг дарга нар болон бусад албаны хүмүүс оролцлоо. Хурлаар баг тус бүр дээр хийгдсэн бүтээн байгуулалтын ажлууд болон цаашид хийгдэх ажлуудын төлөвлөгөөг танилцуулснаас гадна иргэдийн санал, шүүмжийг сонслоо. Удирдлагууд иргэдээс гарсан асуудлуудад газар дээр нь хариултуудыг өгөхөөс гадна зарим асуудлуудыг холбогдох байгууллагуудад уламжилж ажиллахаар боллоо. Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг энэхүү хуралд иргэдийн оролцоо сайжирч мөн иргэдийн дуу хоолойг сонсож байдагт иргэд талархаж буйгаа тус хурлын арга хэмжээний үеэр илэрхийлж байсан юм.

Хяналт шалгалтын тухай: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 06 дугаар тогтоолоор орон нутгийн өмчит зарим хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажил явуулахаар шийдвэрлэж ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамжийг баталсан билээ. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар орон нутгийн өмчийн эзэн нь тухайн шатны ИТХ байдаг тул ийнхүү орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, хурлын тогтоолын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, орон нутгийн өмчийн ашиглалт, хяналтыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэхэд хяналт шалгалтын ажлын зорилго чиглэгдэх юм. Энэхүү шалгалтад "Чандмань Илч" ОНӨХХК /Дорноговь, Сайншанд сум/, "Эм эргэлтийн сан" ОНӨААТҮГ /Дорноговь, Сайншанд сум/, "Тохижилт Сайншанд" хот тохижилтын газар /Дорноговь, Сайншанд сум/, "Чандмань бадрал" ОНӨХХК /Дорноговь, Замын-Үүд сум/, "Замын-Үүд НААҮ" ОНӨХХК /Дорноговь, Замын-Үүд сум/, "Дагшин эрдэнэ" ОНӨХХК /Дорноговь, Эрдэнэ сум/ гэсэн 6-н хуулийн этгээд 3-4 дүгээр сард багтаж тус тус хамрагдана.

Аймгийн ИТХ-ын Санхүү эдийн засаг, төсвийн бодлогын хорооны ахлагч Ч.Энхмэндээр ахлуулсан тус ажлын хэсэгт аймгийн ИТХ-ын төлөөлөгчид буюу бодлогын хороодын дарга, гишүүд, Орон нутгийн өмчийн газрын дарга зэрэг нийт 12 хүн орж байна. Тус ажлын хэсэг өнөөдөр буюу 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдөр "Чандмань-Илч" ОНӨХХК-д хяналт шалгалтын ажлаа эхлүүлээ. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Н.Хонгорзул, Дэд бүтэц, байгаль орчин, хөдөөгийн бодлогын хорооны ахлагч С.Одбаяр, Санхүү эдийн засаг, төсвийн бодлогын хорооны гишүүн Б.Хүдэрболд, Олон нийттэй харилцах хорооны гишүүн Д.Тулга, аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга У.Баярбилэг, аймгийн ажил олгогч эздийн холбооны тэргүүнд Д.Төмөртоогоо нар ажиллаж байна.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн ээлжит 03 дугаар хуралдаан: Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ээлжит 03 дугаар хуралдаан 72,7% ирцтэйгээр хуралдсан юм. Хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцэв:

1. Аймгийн ИТХ-ын ээлжит 10 дугаар хуралдааны тов батлах тухай
2. Төлөөлөгч тойрогтоо хийх ажлын жагсаалт, төсөв батлах тухай
3. Төвийн бүсийн аймгуудын ИТХ-ын уулзалт зөвлөгөөн зохион байгуулах тухай
4. Биеийн тамир, спортын газартай холбогдох өргөдлийг шалгасан ажлын хэсгийн мэдээллийг сонсох тухай
5. Мэргэжлийн комисс байгуулах тухай
6. Дорноговь аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө хэлэлцэх тухай
7. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох асуудалд санал өгөх тухай
8. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахад баримтлах журмыг хүчингүй болгох тухай
9. Монгол Улсын Төрийн дээд шагнал, Алдарт эхийн одонд уламжлах тухай
10. Аймгийн ИТХ-ын даргын цалинг шинэчлэн батлах тухай
11. Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын цалингийн шатлалыг ахиулах тухай
12. Хөрөнгө зарцуулах тухай асуудлууд
- 13 Бусад асуудал

Шагнал: аймгийн ИТХ-ын даргын өргөмжлөл

03 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар Аймгийн ИТХ-ын даргын “Өргөмжлөл”-өөр нийт 13 иргэн шагнагдаад байна.

Аймгийн ИТХ-ын даргын захирамж: 03 дугаар сард нийт аймгийн ИТХ-ын даргын 12 захирамж гарсанаас ангилахад Шагнах тухай-3, Дэмжлэг үзүүлэх-6 Сургалтад хамруулах тухай-1, Хүндэтгэл үзүүлэх тухай-1, Витаминжүүлэлтэд хамруулах тухай-1 тус тус болно.

Аймгийн ИТХ-д ирүүлсэн, явуулсан албан бичиг, өргөдлийн тухайд: Аймгийн ИТХ-ын ажлын албанд нийт 59 албан бичиг ирж, ажлын албанаас нийт албан бичиг гадагшаа 37 байгууллагуудруу явсан болно. Иргэдээс аймгийн ИТХ-д 4 өргөдөл ирүүлсэнээс 4 өргөдлийг шийдвэрлэн хариу хүргүүлсэн болно.

Хоёр. Аймгийн Засаг даргын Тамгын газар

1.1. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс:

Хүний нөөцийн чиглэлээр: Төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв шинээр болон ахиулан олгох тухай асуудлыг Төрийн албаны салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталж аймгийн Засаг даргын шийдвэрээр ахлах түшмэлийн 22,

дэс түшмэлийн 50, туслах түшмэлийн 24 албан хаагчид зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох захирамж гаргалаа. Хүний нөөцийн тоо бүртгэлийн нэгдсэн системд өнөөдрийн байдлаар гарсан өөрчлөлтийг нэмж оруулах талаар сум, байгууллагуудад чиглэл өгч өөрийн байгууллагын 45 албан хаагчийн мэдээллийг шинэчилсэн. Төрийн албан хаагчдын сахилгын шийтгэл хүлээсэн талаарх болон төрийн албаны сул орон тооны, түр орлон гүйцэтгэгч нарын судалгааг авч нэгтгэж байна. Орон нутагт ажиллаж байгаа Удирдлагын академи төгсөгчдийн мэдээллийг бүртгэх ажлыг орон даяар зохион байгуулж байгаатай холбогдуулан өөрийн аймгийн төгсөгчдийг мэдээллээ оруулах талаар үүрэг чиглэлийг албан бичгээр сум байгууллагуудад хүргүүлэн бүртгэлжүүлж байна.

Шагнал, өргөдөл гомдол: Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт хандаж иргэдээс 24 өргөдөл, гомдол ирүүлснээс 20 өргөдлийг нь хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн бөгөөд хугацаа болоогүй судлагдах шатандаа 4 өргөдөл байна. Аймгийн Засаг дарга 2-р сард нийт 22 иргэнийг өөрийн биеэр хүлээн авч, уулзан санал хүсэлтийг шийдвэрлэн ажилласан. Төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2019 оны 1 дүгээр улирлын тайлан мэдээг гарган, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар ирүүлсэн 42 иргэний материалыг хүлээн авч хянан үзээд 28 иргэний материалыг холбогдох дээд байгууллагын саналыг авч аймгийн ИТХ-д хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын шагналаар шагнуулах тухай нийт 56 материал хүлээн авч хянан үзээд аймгийн Засаг даргын Жуух бичгээр 11, өргөмжлөлөөр 36 хүнийг шагнаж урамшуулсан.

Алдарт эх одонгоор шагнуулах 223 иргэний материалыг 14 сумаас хүлээн авч, нягтлан шалгаж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу төрийн албан хаагчдыг чадавхжуулах, туршлага судлуулах зорилгоор Эрдэнэ, Сайншанд, Замын-үүд сумдын 6 багийн Засаг дарга нарыг сум хооронд ажлын 14 хоног сэлгэн ажиллуулж байна.

Засгийн газраас 2019 оныг Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил болгон зарласантай холбогдуулан ирэх 4 сард удирдах болон төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн, сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэн ханган ажиллаж байна.

1.2. Нийгмийн бодлогын чиглэлээр:

Эрүүл мэндийн газар

Өрхийн эрүүл мэндийн төвүүд аймаг, сумын Засаг дарга, ЭМГ-ын дарга нартай үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх гурвалсан гэрээг байгууллаа. Дорноговь аймгийн Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнуудын зөвлөгөөнийг “Эерэг хандлага- чанартай үйлчилгээ” уриан дор 3 сарын 01-02-ны өдрүүдэд зохион байгууллаа. Зөвлөгөөнд аймаг орон нутгийн удирдлагууд, аймгийн эрүүл мэндийн салбарын 50 гаруй удирдах ажилтнууд оролцож, 2018 оны ажлаа тайлагнаж амжилт, алдаа оноогоо хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал бодлоо солилцов. 2018 оны гүйцэтгэлийн гэрээгээр хангалтай сайн гүйцэтгэж, үйл ажиллагаагаараа бусдыгаа хошуучлан идэвх санаачилгатай ажилласан 4 ЭМБ-ыг өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулсан. Зөвлөгөөний хоёр дахь өдөр Удирдлагын академийн багш, доктор Т.Түмэнцогт “Стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй, төрийн үйлчилгээний чанар төрийн албан хаагчаас хамаарах нь” сэдвээр онол дадлага хосолсон сургалтыг зохион байгуулж, мэргэжилтнүүдийн мэдлэгийг дээшлүүлэв.

Аймгийн нэгдсэн эмнэлгүүд, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн ортой эмнэлгүүд, зарим үүдэн эмнэлэг зэрэг нийт 13 ЭМБ-уудад улсын болон аймгийн Мэргэжлийн хяналтын байцаагч нар эмчилгээний чанарын хяналт, эрүүл ахуй халдвар, хамгаалал, цөмийн болон цацраг хяналтын чиглээр хяналт шалгалт хийж, эрсдлийг тогтоох, урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хангуулах зорилгоор 2019.03.18-с эхлэн ажиллаж байна. Энэ долоо хоногт АНЭ, Ачлал, Ач үйлс дэлгэрэх, Идэр өлзийт, Оюутан эмнэлэг, Тэнгэрийн ивээл зэрэг эмнэлгүүдээр хяналт үнэлгээ хийгдэж арга зүйн зөвлөгөө өгсөн байна.

"Амны хөндийн эрүүл ахуй", "НҮЭМ", "Жендэр гэж юу вэ?", "Жендэрийн тэгш харилцаа" "Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралт", "Менингококкын халдвар", "Салхинцэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх" сэдвүүдээр, "Хор зуршил", Бэлгийн ариун цэвэр, БЗДХ-ын халдвар, "Гэдэсний халдвар, Хоолны хордогоос урьдчилан сэргийлье", "Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлье", "Артерийн даралт ихсэлт", "Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралт 2018", "Түлэгдэлтийн үед үзүүлэх анхны тусламж", "Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх нь", "Томуу, томуу

төст өвчнөөс урьдчилан сэргийлэх нь” зэрэг сэдвийн хүрээнд сургалтуудыг зохион байгуулж нийт 500 гаруй сурагчид албан хаагчид ажилтнууд хамрагдлаа.

Сайншанд сумын 4 сургуулийн 12 настай нийт 150 хүүхдийн дунд шүдний өвчлөлийн тархалт, эрчим тогтоох үзлэгийг ахмад эмч Т. Зангадтай хамтран хийсэн. Улаанбурхан өвчний болзошгүй дэгдэлтээс сэргийлэх зарим арга хэмжээний тухай Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09 дугаар албан даалгаврын хүрээнд Улаанбурхан -улаанууд-гахай хавдрын товлолын дархлаажуулалтаас хоцорсон 38 хүүхдийг нөхөн дархлаажуулж, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган 9 удаагийн дотоодын сургалтанд 77 эмч мэргэжилтнүүдийг хамруулсан. Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагууд 32 удаагийн сургалтанд 1123 хүн хамруулж, 13 төрлийн гарын авлагыг 2643 ширхэгийг тараасан.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн Үдийн цайны хэрэгжилтийг хянах зорилгоор ЕБ-ын 4 сургууль, 12 цэцэрлэгийн үдийн цайнд дэмжлэгт хяналтыг 03 сарын 14, 15-ны өдрүүдэд зохион байгуулсан.

МХГ-тай хамтран хүнсний дэлгүүрээр худалдаалагдаж буй 12 төрлийн давсанд агуулагдах иодын хэмжээг тодорхойлох судалгааг гаргасан. Явуулын амбулаторийн үзлэгийн 3 дахь ээлж Мандах, Сайхандулаан сумдад яваад ирлээ.Мандах Сайхандулаан сумын иргэдэд аймгийн ЭМГ-ын мэргэжилтэн Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн чих хамар хоолой, эмэгтэйчүүд, мэдрэл, хүүхэд, дотор, нүд, халдварт, ЭХО, сүрьеэ, рентгенийн эмч, лаборант, рентген техникч, ЭКГ сувилагч нийт 13 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллалаа. Хоёр суманд нийт давхардсан тоогоор 2661 хүн, дан тоогоор 824 хүн хамрагдаж, шинээр 46 өвчлөл илрүүлэн, архаг өвчтэй 614, 2 дахь шатлалын эмнэлэгт 25, 3 дахь шатлалын эмнэлэгт 5 онош тодруулхаар илгээж, сумын ЭМТ-ийн хяналтад 365 хүнийг үлдээсэн.

Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд анхаарч Глобал удирдагч дээд сургуультай хамтран хөнгөлөлтэй үнээр “Эрүүл мэндийн удирдлага” цахим магистрийн сургалтанд 40 гаруй мэргэжилтнүүдийг хамруулахаар бүртгээд байна.

УБ хот ХӨСҮТ-д дархлаажуулалт, хүйтэн хэлхээ, анхан шат, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд “Пневмококк, халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцинуудыг товлолын дархлаажуулалтанд нэвтрүүлэх нь” сэдэвт сургалтанд оролцож, сургагч багшаар бэлтгэгдсэн.

Аймгийн Төмөр замын ажилчдын эрүүл зан үйл төлөвшүүлэх, ажлын байрны дасгалыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, дасгал хөдөлгөөнөөр хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан “Ажлын байрны дасгал” тэмцээнд

НЭМТ- дарга, мэргэжилтэн нар шүүгчээр ажиллалаа. Тэмцээнд 8 байгууллагын 7 багийн 140 ажилчин оролцлоо.

“Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг Дорноговь аймагт хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, орон нутгийн хүн амд үзүүлэх уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амыг уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндээ хамгаалах, мэдлэгийг сайжруулах зорилгоор Дорноговь аймгийн Засаг даргын ивээл дор зохион “Халдварт бус өвчлөлийг УАУ-аар урьдчилан сэргийлэх, эмчлэх нь” бүсийн сургалт, зөвлөгөөн 2019.03.20-21 өдрүүдэд Сайншанд хотноо болж өндөрлөлөө. Сургалт, зөвлөгөөнд урилгаар Эрүүл мэндийн яамны уламжлалтын хэлтсийн дарга З.Балдансугар, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн захирал Ч.Чимэдрагчаа, УАУТХ-ийн эмч мэргэжилтнүүд болон Дорнод, Дундговь, Говьсүмэр, Сүхбаатар аймгуудын уламжлалтын эмч нарын төлөөлөл, Дорноговь аймгийн төр хувийн хэвшлийн эмнэлгүүдийн эмч, сувилагч нийт 100 гаруй төлөөлөл оролцлоо. Мөн Уламжлалт анагаах ухаанаар өвчнөөс урьдчилан сэргийлэх”, “УАУ-ны идээ ундаа” сэдэвт иргэдэд чиглэсэн сургалтыг зохион байгуулж 90 гаруй иргэдийг хамруулж мэдээлэл өгсөн.

Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулах, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, дэмжин хөгжүүлэх, нөхөрсөг хамт олон бүрдүүлэх, туршлагаа харилцан солилцох замаар эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах “Эх хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулъя” сэдэвт урд бүсийн ажил мэргэжлийн уралдаан, Эрүүл нярайн асаргаа сургалтыг Улаанбадрах суманд зохион байгуулан Эрдэнэ сум тэрнүүн байранд, Хөвсгөл сум 2р байранд орлоо.

“Пневмококк, халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцинуудыг товллын дархлаажуулалтанд нэвтрүүлэх нь” сэдэвт орон нутгийн сургалтыг 2019.03.25-нд зохион байгуулж, ЭМБ-уудын 90 гаруй эмч мэргэжилтэнг хамруулан чадавхжууллаа.

Геронтологийн үндэсний төвтэй хамтран Насны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний заавар танилцуулах 30 хүнтэй сургалтанд эрүүл мэндийн байгууллагуудын төлөөлөл оролцлоо.

Боловсролын чилэлээр:

БСУГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 03 сарын 04-нөөс 3 сарын 15-ны хооронд дарга, мэргэжилтнүүд Иххэт, Дэлгэрэх, Алтанширээ, Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах, Зүүнбаянгийн сургууль, цэцэрлэг, соёлын төвийн үйл ажиллагаанд зөвлөн туслах, үйл ажиллагааг үнэлж дүгнэн ажиллалаа. Соёлын төвүүдийн үйл ажиллагааг 16 шалгуур, цэцэрлэгийн үйл ажиллагааг 33 шалгуур, сургуулийн үйл ажиллагааг 15 шалгуур үзүүлэлтээр дүгнэн зөвлөн туслав. Цэцэрлэгийн багш нарт

арга зүйн чиглэлээр сургалт, багш ажилтнаас сэтгэл ханамжийн судалгаа авсан бол сургуулиудын 8, 9, 12-р ангийн сурагчдад “Зөв бичих дүрэм”, багш нарт “Салбарын бодлого чиглэл”, эцэг эхчүүдэд “Хүүхдийн хүмүүжил” сэдвүүдээр сургалт зохион байгуулж, сэтгэл ханамжийн судалгаа авч ажиллалаа.

03 сард зохиогдсон Орос хэлний улсын олимпиадаас сурагч А.Удвал 1-р байр эзэлж алтан медаль хүртэн ОХУ-ын их дээд сургуульд ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр үнэ төлбөргүй суралцах эрхийн бичгээр шагнагдлаа. БСШУСЯ-ны сайдын 2018 оны А/425 тоот “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”, Боловсролын үнэлгээний төвийн 3 сарын 12-ны 01/101 албан бичгийн дагуу 3, 10-р ангийн сурагчдыг түүврээр, 9-р ангийн бүх сурагчдыг бүрэн хамруулан БСУГ-ын 3 сарын 15-ны А/14 тоот тушаалаар томилогдсон комисс Боловсролын чанарын үнэлгээний судалгааг 3 сарын 20, 21-нд амжилттай зохион байгуулж дууслаа. Шалгалтад Сайншанд сумын 1 болон 2-р сургууль Замын-Үүд сумын 1-р сургууль түүврээр сонгогдсон 3, 9, 10-р анги, бусад сургуулиудын 9-р ангиуд хамрагдсан. Нийт 3-р ангийн 216, 9-р ангийн 925, 10-р ангийн 169 сурагч тус судалгаанд хамрагдсан. Мөн тус үеэр сургуулийн захирал, 3, 9, 10-р ангид хичээл заадаг багш нараас судалгаа авсан. БСШУС-ын сайдын 2019 оны А/42 дугаар тушаалын дагуу ЕБС төгсөгч, их дээд сургууль коллежид элсэгчдээс монгол хэлбичгийн шалгалтыг 3 сарын 23-нд зохион байгууллаа. Шалгалтад нийт 320 шалгуулагч орохоос 314 шалгуулагч буюу 98,1% нь хамрагдав.

03 дугаар сарын 23-ны өдөр УИХ-ын гишүүн, Дорноговь аймгийн нутгийн зөвлөлийн тэргүүн Б.Дэлгэрсайхан 5 дахь жилдээ 12-р анги төгсөгчидтэй хийх уулзалтыг зохион байгуулав. Уулзатын үеэр УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан "Шинэ алхам" ЭЕШ-д бэлдэх гарын авлага номыг хүргэж, өөрийн авьяас чадварт тохирсон мэргэжлээ сонгох, төгсөлтийн шалгалтад сайн бэлтгэн ирээдүйд улс орондоо ихийг бүтээх боловсон хүчин болох хэрэгтэйг захиж харилцан яриа өрнүүллээ. Мөн, Замын-Үүд сумын 1 дүгээр сургуулийн төгсөгч А.Удвал 2019-3-14-нд УБ хотод зохиогдсон Орос хэлний улсын олимпиадад 1-р байр эзэлсэн тул УИХ-ын гишүүний тэтгэлэгт хөтөлбөрт 100% хамруулахаар боллоо. Уулзалтын төгсгөлд "Буцаагүй амлалт" уран сайхны шинэ киног төгсөгчдөд үзүүлсэн.

03 сарын 26-нд сургууль бүрээс шалгарсан бага ангийн 20 багшийн дунд Байгалийн ухааны туршилтат хичээлийн уралдаан зохион байгууллаа. Уралдаанд Замын-Үүд сумын 1-р сургуулийн Г.Намуунбайгаль, Замын-Үүд 3-р сургууль Б.Номинчимэг нар тэргүүлж, Сайншанд 2-р сургууль Ө.Өлзийсайхан Сайншанд 3-р сургууль Х.Ганцэцэг нар удаалж, Сайншанд 5 сургууль С.Батзаяа Иххэт Эрдэнэзул нар гутгаар байранд шалгарлаа. “Хөрш орноосоо суралцъя” хөтөлбөрийн хүрээнд аймгийн ИТХ, БСУГ-ын дэмжлэгээр 2019 оны 03 сарын 22-нд Улаанбадрах, Эрдэнэ, Сайншанд сумын 4, 6, 8, 10, 11, 12-р цэцэрлэгийн эрхлэгч, багш нар Эрээн хотын Монгол хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцлаа. Тус үйл ажиллагаанд цэцэрлэгийн 8 эрхлэгч 35 багш хамрагдсан.

03 сарын 25-нд биологи, 03 сарын 26-нд англи хэл, 03 сарын 27-нд газар зүй, 03 сарын 28-нд нийгэм, 03 сарын 28-29-нд технологи, математик, 3 сарын 29-

нд монгол хэл, монголын түүх, 3 сарын 30-нд монгол бичгийн хичээлийн олимпиадууд зохион байгуулав. Биологийн олимпиадад 48 сурагч, 21 багш, газар зүйн олимпиадад 29 сурагч, 12 багш, англи хэлний олимпиадад 40 багш, 63 сурагч, нийгмийн олимпиадад 16 багш, 17 сурагч оролцлоо. Сайншанд сумын 3-р сургуулийн технологийн багш Г.Батбаяр “Улсын шилдэг илтгэл шалгаруулах эрдэм шинжилгээний хурал”-д оролцож 3-р байрт шалгарсан.

Гэр бүл хүүхэд залуучууд хөгжлийн газар: 2019 оныг “Гэр бүлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр хэрэгжиж байгаа хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, тус онд хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулах, иргэд, хүүхдийн санал бодлыг сонсож, үйлчилгээг сайжруулах зорилгоор Айраг, Даланжаргалан, Иххэт, Дэлгэрэх, Алтанширээ, Сайхандулаан, Мандах сумдад удирдамжийн дагуу ажиллалаа. Тус сумдын Хүүхдийн төлөө зөвлөл, Хамтарсан баг, Залуучуудын салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцан арга зүйн зөвлөмж өгч хүүхдийн оролцооны байгууллагын 350 гаруй хүүхдэд арга зүйн зөвлөлөгөө, 235 гаруй иргэдэд салбарын хүрээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, Хүүхэд хүмүүжлийн эерэг арга сургалтыг хүргэлээ.

Хүүхдийн тусламжийн утсанд 2 дуудлага бүртгэгдсэнийг харьяаллын дагуу Замын-Үүд, Айраг сумдад шилжүүлэн хяналт тавьж, хамтарсан багаар нөхцөл байдлын үнэлгээ хийж, сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Аймгийн сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн захирамжийн дагуу тус хэрэгт холбогдох нэхэмжлэгч болон хариуцагч талуудтай уулзаж нөхцөл байдлын үнэлгээ хийж, дүгнэлтийг шүүхэд хүргүүллээ.

Ардын болон хүүхдийн дуу дуулаачдын “Дуулах өв-2019” наадамд 7 сургуулийн 51 сурагч хамрагдсанаас бага насанд Сайншанд сумын ЕБ-ын 2-р сургуулийн сурагч Б.Баярхүү, дунд насанд Сайншанд сумын ЕБ-ын 1-р сургуулийн сурагч С.Нямбаяр, ахлах насанд Сайншанд сумын ЕБ-ын 2-р сургуулийн сурагч Б.Батчимэг тус тус тэргүүн байр эзэлж, улсын уралдаанд оролцох эрх авлаа.

“Нутгийн хөгжилд бидний оролцоо” сэдвийн хүрээнд “SPEAKER-2019” уран илтгэлийн уралдааныг ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж Замын-Үүд, Сайншанд сумдын ЕБС, МСҮТ-ийн 32 суралцагч хамрагдсан. Уралдаан 2 үе шаттай явагдаж амжилттай оролцсон сурагчдыг шагнаж урамшуулав.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хүүхдийн бичгийн хэлний чадварыг нэмэгдүүлэх, захидлын харилцааны соёлыг бий болгох үг, өгүүлбэрээр дамжуулан ойр дотны хүндээ өөрийгөө илэрхийлэх зорилгоор “Сэтгэлийн үгсээ тандаа” захидлын уралдааныг зохион байгууллаа.

Уралдаанд нийт 40 гаруй захидал ирсэнээс шалгарсан 3 захидлыг 3 сарын 8-ны өдөр гэрийн хаягаар нь дурсгалын зүйлийн хамт гардуулан өглөө. Хүүхдийн ордонд шатар, уран нугаралт, мэтгэлцээн, драм, хэлний гэхмэтчилэн 6-н дугуйлан хичээллэж байна. Дугуйланд 111 гаруй хүүхдүүд тогтмол хамрагдан хөгжиж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбар комиссын хуралдаанаар нийт 9 хүүхдийг халамжийн үйлчилгээнд хамруулж, асран хамгаалагч нарт хүүхдээ хэрхэн асрах, хөгжүүлэх талаар зөвлөгөө мэдээлэл өгөв.

Shilendans.gov.mn сайтад тухай бүр, мэдээллийг оруулж хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой тушаалуудыг скайнердаж байршуулсан. Мөн санхүүгийн мэдээллийн самбарт цаасан хэлбэрээр мэдээллээ байршууллаа.

“Малчинд ойрхон мал эмнэлэг” мал эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийн нэгдсэн зөвлөгөөнд оролцогч 50 гаруй хүнд “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх нь” сэдвээр сургалт хийлээ.

Залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх Солонгос хэл, Англи хэл, Илтгэх урлаг зэрэг сонирхлын клуб, төрийн албан хаагч Залуучуудын бүлэг, Сарнай охидын дэмжих бүлэгт нийт 70 гаруй өсвөр үе, залуучууд тогтмол хамрагдан өөрийгөө илэрхийлэх болон хэлний мэдлэгийн түвшингээ ахиулан хуваарийн дагуу идэвхтэй хамрагдан суралцаж байна.

“Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын аяны хүрээнд Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Мандах, Сайхан дулаан зэрэг сумдын 200 гаруй сурагчдад “Мэргэжил сонголт, Зорилго мөрөөдөл” сэдэвт лекц уншлаа.

“Хөөрхөн зүрх” ТББ-аас жил бүр санаачлан зохион байгуулагддаг “Нэг Тэрбумаараа тэмцье” охид, эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг арга хэмжээг Дорнын манлайлагч залуус ТББ, Насан туршийн боловсролын төв, “Говийн хөх салхи” ТББ-тай хамтран зохион байгуулж, энэхүү арга хэмжээнд нийт 200 гаруй өсвөр үе, залуучууд, иргэд дуу хоолойгоо нэгтгэн дэмжин оролцов. Гэр бүлийг дэмжих жилийн хүрээнд Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичгийн хэрэгжилт, 2019 онд хийгдэх ажлын чиглэлийн талаар орон нутгийн телевизүүдэд ярилцлага өгч олон нийтийг мэдээллээр ханган ажилласан.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газар:

2019 оны 03 дугаар сарын 06-ны өдөр “Хөдөлмөр эрхлэлт-Хөгжлийн үндэс” нэртэйгээр хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн №01 тогтоолоор батлагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2019-2020 оны төсөл хөтөлбөрүүдийн нээлт, ажил олгогч, ажил хайгч иргэдийг холбон зуучлах “Хөдөлмөрийн яармаг” арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээнд 200-аад иргэн хүрэлцэн ирж, 2019-2020 онд хэрэгжих төсөл хөтөлбөрүүдийн

талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч, ажил олгогч, ажил хайгч иргэдийн нүүр тулсан ярилцлага боллоо. Ажлын ярилцлагад уул уурхайн 7 компани, 3 ААНБайгууллага оролцож 72 хүнийг нөөцөд бүртгэж шаардлага хангасан хүмүүсийг ажилд авсан байна.

ХХҮГ-ын дарга Д.Цэндмаа болон Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд аймгийн Ажил олгогч эздийн холбооны дарга Д.Төмөртоогоо, холбооны тэргүүлэгчдийн төлөөлөлтэй 2019 оны 03 сарын 05-ны өдөр уулзалт ярилцлага зохион байгууллаа. ХХҮГ-ын зүгээс 2019 онд хэрэгжих төсөл хөтөлбөрүүд, жижиг зээлийн танилцуулгыг хийж, 2 тал ажлын байрны захиалга, ажил зуучлал, мэргэжлийн болон давтан сургалт, ажил хайгч иргэдийн харилцаа хандлага, ажил зуучлахад болон ажилтан авахад, ажилд авсны дараа гардаг хүндрэл бэрхшээлийн талаар ярилцан, харилцан хамтран ажиллахаар боллоо.

“Аймгийн ахмадын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөө” ХХҮГ-ын ХЭХ-ийн үйл ажиллагаа, ахмадын хөдөлмөр эрхлэлт, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх” хөтөлбөрийн талаар мэдээлэл хийлээ.

Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын бүртгэлийн бэлтгэл ажлыг хангаж бүртгэлийг 2019.03.13-15-ний өдрүүдэд зохион байгууллаа. Нийт 55 хүн бүртгүүлснээс 40 эр, 15 эм байна.

Японд тэтгэлэгээр сурч боловсрох арга замын талаар Дорноговийн сайн дурынханы төвтэй хамтран ЕБС-ийн 37 сурагч, 1 насанд хүрэгч иргэнд мэдээлэл өглөө. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг бүлгээр 256, ганцаарчилсан 112 иргэнд үзүүлсэн. 1-р баг дээр “Явуулын бирж” арга хэмжээг зохион байгуулж, төсөл хөтөлбөр, ажлын байрны захиалгыг танилцуулан ажиллалаа. Нийт 46 хүн хамрагдсан байна.

3 дугаар сарын 20-ны өдөр 2019 онд “Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах аймгийн дэд хөтөлбөр”-т хамрагдсан Сайншанд сумын 109 өрхөөс нийт 53 өрхийн хөдөлмөрийн насны 53 иргэнд “Мөрөөдөл-зорилго-амжилт” сэдэвт чиг баримжаа олгох сургалтыг зохион байгууллаа. ХЭДСанд нийт 16 606 000 төгрөг орсноос санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 16 606 000, ХБИ ажиллуулаагүйн төлбөр 0 төгрөг. Өссөн дүнгээр нийт 30 943 500 төгрөг, үүнээс санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 25 183 500, ХБИ ажиллуулаагүйн төлбөр 5760 000 төгрөг байна.

03 дугаар сарын тэтгэвэр, тэтгэмж Төрийн банкаар дамжин олгогдлоо. Нийт 7005 иргэнд 586,7 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж олгожээ. Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн хүрээнд нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг Төрийн банкин дах дансаараа дамжуулан авах боломжтой боллоо.

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.5, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/18 дугаар тушаалаар 2018 оны 07 сараас хойш

шинээр Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдсан болон, дахин үнэлгээ хийлгэж өрхийн амьжиргааны түвшин 670 ба түүнээс доош оноотойгоор үнэлэгдсэн өрхөд, хяналт шалгалт хийгдсэн ба судалгааны үр дүнг ХХҮЕГазарт хугацаанд нь хүргүүлээ.

Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны 46 өргөдөл хүлээн авсан ба эдгээр өрхүүдээр зочилон судалгаа авах ажил хийгдэж байна. Уг судалгаанд хамрагдаж байсан өрхүүдээс судалгааны дүн илт зөрүүтэй бодогдон өрхүдийн мэдээллийг мэдээллийн сангаас шүүн, дүгнэлт хийж ХХҮЕГазарт санал хүргүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна.

ОНОТХҮйлчилгээгээр магадлан итгэмжлэл авах хүсэлтээ аймгийн Улаан загалмайн хороо ХХҮЕГазарт хүргүүлжээ. Уг хүсэлтийн дагуу ХХҮҮГазрын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг гаран газар дээр нь очиж үйлчилгээ явуулах ажлын байр, тоног төхөөрөмж болон боловсон хүчний талаарх мэдэлэлд дүгнэлт хийн ХХҮЕГазарт хүргүүлээ. Дүгнэлтэд уг байгууллага нь сэргээн засах үйлчилгээгээр магадлан итгэмжлэл авахад шаардлага хангахгүй байгаа ба гэрийн асрамж үйлчилгээгээр магадлан итгэмжлэл гаргуулах талаар дүгнэлт гаргалаа.

Тайлант хугацаанд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурал 4 удаа, ХБХЭМБНХСКомиссын хурал 1 удаа хуралдсан ба эдгээр иргэд, хүхдийн мэдээллийг тухай бүр шинэчилэн, мэдээллийн санг сар сараар нь шинэчилэн ажиллаж байна.

Монголын Дауны холбоо ашгийн бус ТББ, Монголын Аутизмын холбоо ТББ-уудтай хамтран Сайншанд сумын дауны хам шинжтэй болон аутизмтай хүүхэдтэй эцэг эх, өрхийн эмнэлгийн эмч, сувилагч, Ерөнхий боловсролын сургуулийн эмч болон холбогдох бусад албаны албан хаагчдад сургалт зохион байгууллаа. Сургалтын зорилго нь дауны хам шинжтэй болон аутизмтай хүүхдүүдийг хөгжүүлэх, боловсрол олгох, эрхийг нь хамгаалах, нийгэмд эерэгээр таниулах, эцэг эхчүүдийг нь чадавхжуулахад хувь нэмрээ оруулах явдал юм. Сургалтын дараа эцэг эхчүүд холбогдох хүмүүсээс ганцаарчилсан зөвлөгөө, сэтгэлийн дэмжлэг авлаа.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих өрөөнд оёдол эсгүүрийн чиглэлээр ажиллах сонирхолтой зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг бүлэг болгон ажиллуулж байна. Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор байгууллага, иргэдэд үйл ажиллагааг сурталчилан ажиллалаа. Одоогийн байдлаар Өргөн сумын засаг даргын тамгын газар, Мон цемент буйлдинг материал ХХК-уудад бээлий болон даавуун тор нийлүүлэхээр болоод байна.

Зорилтот бүлгийн олон хүүхэдтэй өрх толгойлсон иргэдийн судалгааг гарган “Дорноговь сайн дурынхны төв” төрийн бус байгууллагад хүргүүлэн 10 эмэгтэйд хандивын хувцас хэрэглэлийг гардуулсан.

Зорилтот бүлгийн өрхийн хөдөлмөрийн насны иргэдийн дунд “Мөрөөдөл-Зорилго-Амжилт” сэдэвт сургалтыг ХЭХэлтэстэй хамтран зохион байгууллаа. Сургалтаар тус газраас зарлаж буй хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрийн талаарх танилцуулга мэдээллийг иргэдэд өгсөн. Энэхүү сургалтанд Сайншанд сумын зорилтот өрхийн 53 иргэн хамрагдсан.

Зорилтот бүлгийн иргэдийн амьдралын нөхцөл байдалд үнэлгээ хийж, шаардлагатай байгаа тусламж хөнгөлөлтийг чирэгдэлгүй олгох үүднээс газрын даргаар ахлуулсан баг өрхүүдээр зочилж ажиллалаа. Энэ үеэр ХХҮГазрын үйл ажиллагаа болон ХЭДСангийн төсөл хөтөлбөрт хэрхэн хамрагдах талаар зөвлөгөө мэдээлэл өглөө.

1.3. Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 2018 оны дараах багц тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Үүнд:

1. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн 2018 оны биелэлт
2. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн 2018 оны тайлан
3. Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын 2018 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт
4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх 2017 оны хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар гарсан зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан
5. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2018 оны үйл ажиллагааны тайлан
6. Аймгийн 2018 оны “Онцлох ажлууд” /видео хэлбэрээр/
7. Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа” үйл ажиллагааны хөтөлбөрийн 2018 оны хэрэгжилт /видео хэлбэрээр/ болно.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан хэлтсийн эрхлэх асуудлын хүрээний 56 баримтыг үдэж архивлан, жагсаалт үйлдэж бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгсөн.

Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн 2019 оны дотоод ажил үүргийн хуваарийг гаргалаа. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг албан хаагч бүрээр боловсруулан бэлтгэсэн. Хэлтэст хөтлөгдвөл зохих албан бичгийн бүртгэлийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэн үндсэн чиглэлийн биелэлтийг цахимаар авахтай холбогдуулан сумд, агентлагийн дарга, холбогдох мэргэжилтнүүдийн эрхийг “Аймгийн хяналт шинжилгээний үнэлгээний мэдээллийн цахимд сан”-д нээлгэх, байгууллага тус бүрийн холбогдох заалтуудыг цахим санд оруулах ажлыг байгууллагын холбогдох мэргэжилтэнтэй хамтран гүйцэтгэлээ.

2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгох тухай Засгийн газрын 2019 оны 23 дугаар тогтоолын арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоолын хэрэгжилтийг тус тус холбогдох

хэлтсүүдээс гаргуулан авч, 2019 оны 03 дугаар сарын 28-ны дотор хяналт шинжилгээ, үнэлгээний цахим системд оруулан баталгаажуулсан байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний системд 1 дүгээр улирлын байдлаар тавигдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтээс Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, албан даалгаварыг нэг бүрчлэн шүүж хэрэгжилт бүрэн хангагдсан, цаг хугацааны хувьд ач хоблогдолгүй болсон, нэг удаагийн шинжтэй заалтуудыг системийн хяналтаас хасуулахаар саналыг хүргүүлэн, программд баталгаажуулан ажилласан.

Аймгийн хэмжээнд “Хяналт шинжилгээ үнэлгээний мэдээллийн цахим сан”-г нэвтрүүлэхтэй холбогдуулан үнэлгээний хороо байгуулан, “Ухаалаг засаглал” төрийн бус байгууллага шалгаран хамтран ажиллах гэрээ байгуулж, ажлыг эхлүүлээд байна.

Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамжийг ирсэн тухай бүр нь аймгийн удирдлагууд болон холбогдох хэлтэс, агентлагт танилцуулах ажлыг зохион байгуулж байна.

“Аймгийн өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээ” сэдэвт уулзалт ярилцлагыг агентлагийн дарга, мэргэжилтнүүдийг хамруулан 50 гаруй албан хаагчдад зохион байгуулсан.

Цаг үеийн болон бусад арга хэмжээ: Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчин байгуулагдсаны 98 жилийн ойн баярын хүрээнд байгууллагын эрчүүдийг баярлуулах арга хэмжээнд хэлтсийн мэргэжилтнүүд бүрэн бүрэлдэхүүнтэйгээр оролцлоо.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны А/38 дугаар тушаалаар аймгийн төв номын сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулах ажлын хэсэгт хэлтсийн мэргэжилтэн Ш.Алимаа оролцон ажилласан.

1.4. Санхүү, төрийн сангийн чиглэлээр:

Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаанд нь гаргаж ажилласан. Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн 2 дугаар сарын мэдээгээр төсвийн нийт урсгал орлого 4968.2 сая төгрөг төвлөрхөөс гүйцэтгэлээр 3497.6 сая төгрөг төвлөрсөн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 70.4 хувь буюу 1455.9 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Тасарсан орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Бууны албан татвар 51.1%, Улсын тэмдэгтийн хураамж 89.2%, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 98.7%, Хог хаягдлын үйлчилгээний хураамж 54.6%, Газрын төлбөр 49%, Торгуулийн орлого 23.6%, Түрээсийн орлого 57.7%, Бусад татвар 61.3%, Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 28%, Газрын дуудлага худалдааны орлого 92.9 хувиар тус тус тасарлаа.

Айраг, Алтанширээ, Иххэт, Мандах, Өргөн, Сайхандулаан, Улаанбадрах, Хөвсгөл, Эрдэнэ, Сайншанд сумд орлогын төлөвлөгөөг 111.78-475.75 хүртэл хувиар давуулан биелүүлж, бусад төсвийн захирагч нар 31.59-72.63

хүртэл хувиар орлогын төлөвлөгөөг тасалдуулаад байна. Замын-Үүд сумаас орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого 950.0 сая төгрөгөөс 400.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Тусгай зориулалтын шилжүүлгээр эрх нь шилжиж ирсэн байгууллагуудын төлөвлөгөө 2792.0 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 2792.0 сая төгрөгөөр санхүүжилтийг 100 хувиар олгосон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 1912.8 сая төгрөг, Орон нутгийн хөрөнгө оруулалтанд 1150.0 сая төгрөгийн санхүүжилтийг холбогдох бичиг баримтыг үндэслэн санхүүжилтийг олгосон.

Шилэн дансны мэдээллийн системд 2 дугаар сарын санхүү, хөрөнгө оруулалт, төсвийн талаарх холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд нь байршуулсан.

Төсвийн байгууллагуудын 3-р сарын зарцуулалтын эрхийн хүсэлт баталгааг батлагдсан хуваарийн дагуу хянаж хэлтсийн даргаар баталгаажуулан хүлээн авсан. 37 төсөвт байгууллагын данс, 37 нэмэлт төсвийн данс, 25 сангийн данс нийт 97 дансны 2.5 тэрбум төгрөгийн 1325 ширхэг зарлагын гүйлгээг программд шивж төв төрийн санд дамжуулсан. Төсвийн байгууллагуудаас ирүүлсэн ахмадын сангийн зарцуулах хүсэлтийг үндэслэн 3 удаагийн хүсэлтээр 3.6 сая төгрөгийн хүсэлтийг Сангийн яаманд цахимаар хүргүүлж эрхийг нээлгэж ажилласан.

Орон нутагт тусгай зориулалтын шилжүүлгээр эрх нь шилжиж ирсэн байгууллагуудын 03 дугаар сарын санхүүжилтийн эрхийг батлагдсан хуваарийн дагуу төсвийн ахлах мэргэжилтнээр хянуулан хэлтсийн даргаар батлуулан эрхийг нээсэн.

Сумдын санхүүгийн дэмжлэгт 1422.0 сая төгрөг, Төсөвт байгууллагуудын санхүүжилт 1494.8 сая төгрөгийг олгохоос 1494.8 сая төгрөгийн 100 хувь санхүүжилтийг олгосон. Халамжийн санд 30.7 сая төгрөгийг олгохоос 30.7 сая төгрөгийг олгож 100 хувь санхүүжилтийг олгосон. Сумдын төрийн сангийн өдөр тутмын гүйлгээнд e-report системээр хяналт тавьж алдаа зөрчлийг залруулсан.

Төсвийн байгууллагуудаас ирүүлсэн нэмэлт төсвийн зарцуулах хүсэлтийг үндэслэн Онцгой байдлын газар 3.5 сая төгрөг, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар 1.2 сая төгрөг, Биеийн тамир спортын газар сая төгрөг, Боловсрол соёл урлагын газар 2.5 сая төгрөг, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар 3.5 сая төгрөг, Зүүнбаян тосгоны Биеийн тамир спортын төв 2.8 сая төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газар 15.4 сая төгрөг, Хүнс хөдөө аж ахуйн газар 5.0 сая төгрөг, Нэгдсэн эмнэлэг 10.3 сая төгрөг, Статистикийн хэлтэс 2.1 сая төгрөг, Эрүүл мэндийн газар 0.8 сая төгрөгийн ирүүлсэн хүсэлтийг үндэслэн төсвийг Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд зарцуулах эрхийг нээж төлбөр тооцоог шуурхай хийж гүйцэтгэлээ.

Сумдын орон нутгийн байгууллагууд болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын нягтлан бодогчдод төрийн сангийн бүртгэлийн дансны хуулгыг онлайнаар харах эрхийг нээлгэх хүсэлтийг Сангийн яамны төрийн сангийн газарт албан бичгээр хүргүүлж ажилласан.

3 аж ахуй нэгж байгууллагын дуусгалтын тайлан хүлээн авч баталгаажуулж ажилласан. 1 аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг өөрчилж ажилласан. Мөн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 86.0 хувьтай баталгаажуулж ажилласан. Шинээр байгуулагдсан 1 аж ахуй нэгжийг системд бүртгэж 35 аж ахуй нэгж байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланд засвар оруулж ажилласан. Сумдын 2018 оны санхүүгийн нэгтгэн аудитлагдсан тайланг баталгаажуулах ажил хийгдэж байна. Тайлангийн ирц 80 хувьтай байна. Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах ажил хийгдэж Сангийн яаманд хүргүүлж татуулж ажилласан.

Татварын хэлтэс: Улс ба орон нутгийн төсөвт 2348410.7 мянган төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн. Тайлант хугацаанд 2117 татвар төлөгчөөс 5 төрлийн тайланг хүлээн авч ажилласан. 1164 татвар төлөгчдөд Татварын хууль, НӨАТ-ын урамшууллын системээр зөвлөгөө зааварчилгаа өгч ажиллалаа.

Аймгийн Улсын бүртгэлээс шинээр үүсэн байгуулагдсан 8 хуулийн этгээд болон нэмэлт өөрчлөлт хийгдсэн 8 татвар төлөгчдийн мэдээллийг хүлээн авч, НӨАТ төлөгчөөр шинээр бүртгэгдсэн 5 татвар төлөгчийн мэдээллүүдийг баазад тухай бүр шивж оруулан шинээр үүсэж байгаа татвар төлөгчдөд татварын багц хуулиар зөвлөгөө өгч ажиллалаа. Татварын хэлтсийн даргын баталсан удирдамж болон татвар төлөгчөөс хасагдах хүсэлтийн дагуу 8 татвар төлөгчийг татварын хяналт шалгалтанд хамруулсан.

Татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх, нуугдмал орлогын эх үүсвэрийг бий болгох ажлын хүрээнд 8 байгууллагаас 3618.6 сая төгрөгийн 153 мэдээллийг цуглуулж нэгтгэн тасгуудыг мэдээллээр ханган ажиллалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа 22 төлбөр төлөгчөөс 7 төлбөр төлөгчийн 38,7 сая/төг-ийг хэсэгчлэн барагдуулж Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албатай тооцоо нийлж ажиллалаа.

Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн программд нийт 46 албан хаагчийн мэдээллийг шинэчлэн оруулж дуусгалаа.

Татварын албанаас нэхэмжлэлд суурилсан цахим төлбөрийн системийг шинээр хөгжүүлсэн. Энэ ажлын хүрээнд арилжааны зургаан банкттай системийн хөгжүүлэлт хийгээд, 2019 оны гуравдугаар сарын 01-ээс цахим төлбөрийн системийг орон даяар нэвтрүүлж эхэллээ. Сангийн яам, Татварын ерөнхий газар, арилжааны банк гэсэн гурван талт “тэг” үлдэгдэлтэй дансны гэрээг Улаанбаатар хотын банк, ХААН, ХХБ, Хас, Голомт, Төрийн банк гэсэн арилжааны банкуудтай байгуулсан.

Татвар төлөгч татвараа төлөхдөө дээрх зургаан банкны интернэт банкийг ашиглаж цаг хугацаа орон зайнаас үл хамааран татвараа төлдөг болоод байна. Татвар төлөгчдөд заавар зөвлөгөө өгч нэхэмжлэл үүсгэн ажиллаж байна.

Санхүүгийн хяналт, Аудит алба: Монгол улсын Сангийн сайдын баталсан удирдамж, албаны даргын баталсан 2019.01.30-ны өдрийн 02 тоот удирдамжийн дагуу аймгийн Нийгмийн халамжийн сангийн 2017-2018 оны үйл ажиллагаанд хяналт шалгалтыг 2019.02.11-нээс 03-19-ныг дуусталх хугацаанд гүйцэтгэж, 2019.03.22-ны өдрийн 10⁰⁰ цагт шалгалтын дүнгийн хурлыг хийж, шалгалтын тэмдэглэл, холбогдох судалгаа, материалыг Сангийн яамны Санхүүгийн хяналт,

Эрсдэлийн удирдлагын газарт 2019.03.22-ны өдрийн 65 тоот албан бичгээр хүргүүллээ.

Монгол улсын Сангийн сайдын баталсан удирдамж, албаны даргын баталсан 2019.01.30-ны өдрийн 01 тоот удирдамжийн дагуу аймгийн Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн сангийн 2017-2018 оны үйл ажиллагаанд хяналт шалгалтыг 2019.01.31-нээс 03-19-ныг дуусталх хугацаанд гүйцэтгэж, 2019.03.22-ны өдрийн 11³⁰ цагт шалгалтын дүнгийн хурлыг хийж, шалгалтын тэмдэглэл, холбогдох судалгаа, материалыг Сангийн яамны Санхүүгийн хяналт, Эрсдэлийн удирдлагын газарт 2019.03.22-ны өдрийн 66, 67 тоот албан бичгээр тус тус хүргүүллээ.

Монгол улсын Сангийн Яамны Санхүүгийн хяналт, Эрсдэлийн удирдлагын газрын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, албаны даргын баталсан 2019.03.07-ны өдрийн 03 тоот удирдамжийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарах төсвийн болон орон нутгийн өмчид аж ахуйн нэгж, байгууллагуудын 2018 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг 2019.03.04- ний өдрөөс эхлүүлж, хяналт шалгалт үргэлжлэн хийж байна.

Дотоод ажил хариуцсан ажилтан 2018 оны хяналт шалгалтын холбогдолтой үүссэн баримтуудаар 2 ширхэг хадгаламжийн нэгж үүсгэж, Замын Үүд сумын ИТХурал, ЗДТГазар, ЗААлба, “Борхойн наран “ ӨЭМТөв, Нэгдсэн эмнэлэг, Чандмань Бадрал ХХК зэрэг байгууллагуудын шалгалтын материалыг цахимжуулан архивлалаа.

Статистикийн хэлтэс: Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын аймгийн комиссын анхдугаар хурлыг 2019 оны 03 сарын 4-ний өдөр зохион байгуулав. Тооллогын комиссын гишүүдэд хэлстийн дарга Х.Өлзийсүрэн тооллогыг зохион байгуулж явуулах эрх зүйн үндэслэл, зорилго, удирдлага зохион байгуулалт, мэдээлэл цуглуулах арга, хэлбэр, хамрах хүрээний талаархи дэлгэрэнгүй мэдээллийг танилцууллаа. Мөн энэ үеэр ээлжит тооллогын аймгийн комиссын ажиллах журам, гишүүдийн чиг үүргийн талаар танилцуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлав.

Сарын аж үйлдвэр /Аж Үйлдвэр-1/, хөдөө аж ахуйн /Хөдөө Аж Ахуй-2, Хөдөө Аж Ахуй-3/ салбарын мэдээ тайланг 14 сум, 60 гаруй аж ахуйн нэгж, иргэдээс, хэрэглээний бараа, үйлчилгээний 230 гаруй төрлийн үнийг 5 сум, 60 гаруй нэгжээс, зочид буудал, зоогийн газар, холбоо, тээвэр, барилгын салбарын үйлдвэрлэгчийн үнийн мэдээ, тайланг 21 аж ахуйн нэгжээс цуглуулан авч, програмд шивж, алдаагүй мэдээллийг Үндэсний статистикийн хороонд дамжуулав.

2018 оны жилийн эцсийн мэдээлэгчийн хүрээний дагуу 597 аж ахуй нэгжийн жилийн эцсийн мэдээ, тайланг авч, шалган програмд шивж, Үндэсний статистикийн хороонд хугацаанд нь дамжууллаа.

Аж үйлдвэр, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ судалгаа, чөлөөт цаг, биеийн тамир спорт, тээвэр, холбооны салбарын жилийн эцсийн мэдээний

тодруулгыг хийж, засварлах шаардлагатай мэдээллийг засварлан Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн.

Аймгийн нийгэм, эдийн засгийн 2019 оны 2-р сарын танилцуулга болон илтгэлийг бэлтгэж цахимаар хэрэглэгчдэд тархааж, мөн facebook болон цахим хуудсанд байршуулсан.

Орон нутгийн DTV телевизтэй хамтран иргэдэд мэдээлэл хүргэх ажлыг сар бүр зохион байгуулж байгаа бөгөөд энэ удаагийн мэдээллийг аймгийн нийгэм, эдийн засгийн 2019 оны 2-р сарын танилцуулгаар хэлтсийн мэргэжилтэн А.Амарзаяа хүргэлээ.

Хүн ам, аж үйлдвэр, үнэ, хөдөө аж ахуй, дотоодын нийт бүтээгдэхүүн, бизнес регистрийн сангийн статистик үзүүлэлтээр олон жилийн динамик тоон мэдээлэл бэлтгэн хэлтсийн вэб хуудсанд байршууллаа.

Үндэсний статистикийн хорооны Эдийн засаг статистикийн газраас худалдаа, хөрөнгө оруулалт, аж үйлдвэр, зочид буудал, зоогийн газрын салбарын сар, улирал, жилийн мэдээний талаар онлайн хэлбэрээр 03 сарын 22-ны өдөр зохион байгуулсан бөгөөд сургалтанд хэлтсийн дарга мэргэжилтнүүд бүгд хамрагдсан. Мөн 03 сарын 22-ны өдөр Ажиллах хүчний судалгааны албанаас Ажиллах хүчний судалгааны аргачлал, асуулга заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор онлайн хэлбэрээр зохион байгуулсан сургалтанд судалгааны багийн ахлагч, 2 судлаач хамрагдав.

Орон нутгийн өмчийн газар: Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний нэгтгэл тайлангийн явц 98 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Чандмань-Илч ОНӨХХК-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажлыг 2019 оны 03 сарын 05-28-ны өдрийг хүртэл хугацаанд гүйцэтгэлээ.

Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн санал хүлээн авч аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд оруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Замын-Үүд суманд бэлтгэгдсэн хөрөнгийн асуудлаар заавар зөвлөмж өгч ажилласан.

Хөрөнгийн нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулж 1 ширхэг авто машин зарагдаж аймгийн хөрөнгө худалдан борлуулсны орлогын дансанд 1 200 000 төгрөг төвлөрүүлэн ажилласан.

Захиргааны зөвлөлд аймгийн Мэргэжлийн хяналтын газар хураагдсан эд зүйлсийг хүлээн авч, зөвлөлийн хуралд хэлэлцүүлэн устгах шийдвэр гарсан хөрөнгийг устгах ажлыг зохион байгуулсан.

Худалдан авах ажиллагааны хүрээнд: 2019 оны аймгийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг хялбаршуулсан 35 ажлыг цахим системээр зарласан.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу зарласан дараах төсөл арга хэмжээнд нээлт хийж 22 тендерт нарийвчилсан үнэлгээ хийж байна.

Гэрээ байгуулсан 15 төсөл арга хэмжээ байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу зарласан дараах төсөл арга хэмжээнд нээлт хийх 20 төсөл арга хэмжээ байна.

1.5. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр:

Хөрөнгө оруулалтын ажлын талаар: 2018 оны Төсвийн тухай хуулиар батлагдаж, Барилга хот байгуулалтын яамнаас орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг гаргаж, БХБЯ-нд албан бичгээр хүргүүлсэн. Сайншанд сумын Зүүнбаян багийн орон сууцны халаалтын талаар Засгийн газрын 11-11 төвд гаргасан гомдлын дагуу судалж хариу мэдэгдэхийг Сайншанд сумын Засаг дарга болон Чандмань-Илч ОНӨ ХХК-д албан бичиг хүргүүлсэн. Улсын болон орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн тайланг эх үүсвэр тус бүрээр гарган аймгийн Аудитын газарт албан бичгээр хүргүүлсэн.

Нийтийн тээврийн үйлчилгээнд бага оврын 4 ш автобус худалдан авах ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Ди Өү Сапплай ХХК-д гэрээний дагуу 167.6 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг олгосон.

Аймгийн ЗДТГ-ын хурлын танхимын ширээг засварлах Хуршанд ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Өргөн сумын ундны усны нөөцийн савыг шинэчлэх ажлын гүйцэтгэгч Ингүүмэл-Оргил ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. УАУРСТ-ийн дээврийн засварын ажлын гүйцэтгэгч Чонот девелопмент ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн лабораторийн тасгийн шинжилгээ авах өрөөний засварын ажлын гүйцэтгэгч Энержи парагон ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Монгол улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкттай хамтран хэрэгжүүлэх “Төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн мэдээллийн систем байгуулах” төслийн хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт хариуцсан албан тушаалтны тоног төхөөрөмжийг шинэчлэхтэй холбогдуулан ХОХБТХ-ийн ахлах мэргэжилтэний одоо хэрэглэж байгаа болон шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж Сангийн яаманд хүргүүлсэн. Дорноговь их хөгжил сангийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх зарим ажлын зураг төсвийг ТУЗ-ийн даргад хүргүүлсэн.

Үндэсний хөгжлийн газраас боловсруулж буй “Бүсчилсэн хөгжлийн бодлого”-ын хүрээнд сумдад зохион байгуулах хэлэлцүүлгийн талаар бүх сумдын Засаг дарга нарт албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн.

Төрийн сангаас зохион байгуулсан сургалтын үеэр бүх сумдаас ирсэн албан тушаалтнуудтай уулзаж, сумын ОНХС-ийн гүйцэтгэлийн талаар зөвлөгөө өгч ажилласан. Улс, орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын ажлын явц, зарим ажлын зураг, төсвийн талаар ГХБХБГ болон ОНӨГ-ын холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, ажлыг эрчимжүүлэх талаар хэлэлцсэн.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.9-д заасны дагуу аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтийн 2018 оны тайланг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлсэн. Сайншанд сумын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төв болон 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга, мөн Замын-Үүд сумын 500 хүний суудалтай Соёл спортын цогцолборын үлдэгдэл санхүүжилт Сангийн яамнаас орж ирсэнийг гүйцэтгэгч компанид олгосон.

Дорноговь их хөгжил сангийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх ажлын саналыг бүх сумаас авч нэгтгэн жагсаалтыг албан бичгээр ТУЗ-ийн даргад хүргүүлсэн. Дорнын их говь гэрэл зургийн цомгийг нэмж 1000 ширхэгийг худалдан авах захирамжийг боловсруулж, гэрээг байгуулсан. Хүүхдийн ордны гадна зам талбайн ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Дорноговь-АЗЗА ХХК-тай гэрээ байгуулсан. Багийн Засаг дарга нарт олгох 15 ш мотоциколь худалдан авах тендерт шалгарсан Арвайн хурд ХХК-тай гэрээ байгуулж, урьдчилгаа 12.6 сая төгрөгийг олгосон. Аймгийн ОБГ-т автомашин худалдан авах тендерт шалгарсан Мэжик бонд ХХК-тай гэрээ байгуулсан.

Барилга хот байгуулалт газрын харилцааны чиглэлээр : Аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн бичиг баримтыг хянаж, иргэн аж ахуйн нэгж байгууллагад газар өмчлүүлэх, газар эзэмшүүлэх, дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай 4 захирамжийн төслийг боловсруулж шийдвэр гаргуулсан.

Сайншанд суманд баригдах 1000 хүний суудалтай Спорт цогцолборын зураг төсөл, төсвийг зохиогчоос авч аймгийн ГХБХБГ-т хүргүүлэн ажлын тоо хэмжээг гаргуулсан.

БХБЯ-нд 50 ортой төрөх эмнэлэг, БСШУЯ-нд Хатанбулаг сумын Спорт цогцолборын барилга угсралтын ажил болон Мандах суманд баригдах 100 ортой цэцэрлэгийн зураг төсөл, төсвийн талаар БХБЯ, БСШУЯ, ЭМЯ-ын холбогдох дарга мэргэжилтнүүдэд асуудлыг танилцуулж, асуудлыг шийдвэрлүүлэхээр орон нутгийн саналыг боловсруулж албан бичиг хүргүүлсэн.

Алтанширээ сумын инженерийн дэд бүтцийн цахилгааны техникийн нөхцөлийг хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулж БЗӨБЦДС ХХК болон УИХ-ын гишүүнд дэмжлэг хүссэн албан бичиг хүргүүлээ.

Орон нутгийн бүтээн байгуулалтад оролцох орон нутгийн барилгын компаниуд болон зам засвар, цахилгааны шугам угсралт, барилгын материал үйлдвэрлэгч 14 компанийн төлөөлөлийг аймгийн Засаг даргатай уулзалт зохион байгуулж, санал хүсэлтийг нь сонсон 2019 онд хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцож орон нутгаас үзүүлэх дэмжлэгийн талаар тохиров.

Аймгийн Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, 2019 оны ажлыг төлөвлөгөөг боловсруулан зөвлөлийн орлогч дарга нарт хянуулахаар хүргүүлсэн.

Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн дотуур байрны засварын ажлыг Япон улсын ЭСЯ-ны Өвсний үндэс хөтөлбөрөөс үзүүлж буй 200 сая төгрөгийн буцалтгүй тусламжийн төслийн гэрээнд гарын үсэг зурах ёслолын үйл ажиллагааны үеэр гаргах орон нутгийн брэндийн үзэсгэлэн, танилцуулга, фото зурган мэдээллийг бэлтгэж, шаардлагатай мэдээллийг бэлтгэн ЭСЯ-нд хүргүүлэв.

Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөний саналыг авахаар холбогдох байгууллагуудад хандаж сарын аянд идэвхтэй оролцох чиглэлийг албан бичгээр өглөө.

ЗДТГ-ын засвартай холбоотой асуудлаар Тольт дэнлүү ХХК-тай холбогдож чанарын доголдол гарсан ажлуудыг дараагийн 7 хоногт дахин хийлгүүлэхээр тохиров.

Барилга угсралтын ажил эхлүүлэхээр хүсэлт ирүүлсэн 4 материалыг хянаж 3 зөвшөөрөл олгож, бичиг баримтын бүрдэл дутуу 1 хүсэлтэд дутуу баримт бичгийг нэмж бүрдүүлж ирэхийг зөвлөж албан тоот хүргүүлээ.

2018 онд Улс орон нутгийн төсвийн хөрөнг оруулалтаар ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээг гаргасан. Сумдын газрын даамлуудын нэгдсэн сургалт зөвлөгөөнийг зохион байгуулсан. ГХБХБГ-аас ирүүлсэн материалыг хянаж, аймгийн Засаг даргын захирамжаар 1 аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлсэн. Газар хөдлөлийн гамшгийн эрсдэлийг бууруулах байнгын ажиллагаатай зөвлөлийн 2019 оны төлөвлөгөөний саналыг холбогдох байгууллагуудаас авч нэгтгэн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон.

Барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл хүссэн 1 материалыг хянаж ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон. Японы Элчин сайдын яамны Өвсний үндэс хөтөлбөрийн 200 сая төгрөгийн буцалтгүй тусламжаар ЕБ-ын 1-р сургуулийн дотуур байрны засварын ажлыг гүйцэтгэх төслийн гэрээнд гарын үсэг зурах ёслолын ажиллагаатай холбоотой зарим бичиг баримтыг бэлтгэж ЭСЯ-руу явуулсан. Сумдад баригдах 9 айлын орон сууцны жишиг зураг төслийг сумдад хүргүүлсэн.

Байгаль орчны аялал жуулчлалын газар: БХНСЗ-аар Сайхандулаан, Иххэт, Өргөн, сумдад хийгдэх эзэн холбогдогчгүй газрын нөхөн сэргээлт хийх төслийг 2019 оны 03 дугаар сарын 30-ны өдөр ирүүлэх албан бичгийг сумдад хүргүүлсэн.

БОНБЕУ хийлгэсэн 141 аж ахуй нэгжид хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, хэрэгжилт хангалтгүй байгаа тул Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу авч хэрэгжүүлэх ажлын чиглэлийг сум, аж ахуй нэгжид хүргүүлсэн.

Сайншанд сумын хүн амын усан хангамжийн хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэгч “Эрдэнэ дрийлинг” ХХК-тай уулзалт зохион байгуулж, худаг гаргах зөвшөөрөл олгох талаар хамтран ажиллахаар болсон.

2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Дэлхийн усны өдрийг зохион байгуулж, ЕБС-ийн 1-5 /бага/, 6-9 /ахлах/ дүгээр ангийн сурагчдын дунд гар зургийн уралдаан зохион байгуулж, 100 гарын авлага тараасан. Нийт 84 бүтээл ирүүлсэн. Амжилттай оролцсон сурагчдад шагнал гардуулах ажлыг зохион байгуулсан.

Нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулж албан хаагчдыг урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. Аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг аймгийн ИТХТ-ээр хэлэлцүүлсэн.

Тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн санг цэгцлэх ажлын хэсгийг байгуулж, аймаг, сумын хүчин төгөлдөр тогтоолыг Ашигт малтмал, Газрын тосны газрын кадарстрын бүртгэлийн системтэй тулгах ажлыг хийсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээнд заасны дагуу ЕБСургуулиудын сурагчдын дунд “Хандлагаа өөрчилье” арга хэмжээг хавар намар зохион байгуулахаар сарын аяныг удирдамжийг аймгийн Боловсрол, соёл урлагийн газартай хамтран батлуулаж сургуулиудад хүргүүлсэн.

Хэлтэсээс зохион байгуулсан ажил: 2019 онд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэн хийгдэх 3 арга хэмжээний захирамжийг гарган харьяа байгууллагад хүргүүлсэн.

Мандах суманд Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгосон.

Салбарын ажилтай холбоотой 15 бичиг төлөвлөн холбогдох газруудад хүргүүлсэн. 03 дугаар сарын 22-ны өдөр "Цэнгэг ус-Тэгш хүртээмж" уриан дор Дэлхийн усны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагуудтай хамтран гаргаж гарын авлага, кино, шторкийг орон нутгийн телевизид хүргээд байна.

Галба-Өөш Долоодын говийн сав газрын захиргаа, БОАЖГазар, "Чандмань-Илч" ОНӨХХКомпани, ХХААГазар хамтран 2019.03.14-ны өдөр Сайншанд сумын "Ус хангамжийн аялал"-ийг Ерөнхий боловсролын 1,2,3,5-р сургуулийн эко клубын гишүүд нийт 32 сурагчдыг хамруулан зохион байгууллаа. Аялалаар Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны үйл ажиллагаатай танилцаж, гүний усны талаар мэдээлэл олгох сургалт хийсэн.

“Чандмань-Илч” ОНӨХХК-ийн үйл ажиллагаатай танилцаж Сайншанд сумын ус хангамжийн эх үүсвэр Зээгийн хөтөлийн ус хангамжийн худгууд, ус өргөх станцууд, төв усан сан, хлоржуулах байртай танилцсан.

Мөн "Амин-ус" цэвэр усны үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцуулж, Эко клубын шинэ гишүүдэд "Ногоон паспорт" гардуулах зэрэг үйл ажиллагаа зохион байгууллаа.

Эрүүл мэндийн газартай хамтран Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн сурагчидад усыг хэмжнэх дахин ашиглах, эрүүл ахуйн чиглэлээр сургалт зохион байгуулж 89 сурагчидад мэдээлэл өгч ажиллалаа.

Аймгийн Төв номын санд усны салбарын номын булан тохижуулах, мэргэжлийн болон олон нийтэд зориулсан ном, лавлах толь, товхимол, гарын авлага зэрэг хандивлалаа.

Тусгай хамгаалалттай газар нутгийн хугацаа дуусах болон шинээр тусгай хамгаалалтад авах, тусгай хамгаалалтад авсан боловч Ашигт малтмал, Газрын тосны газрын мэдээллийн санд бүртгэгдээгүй газруудад дүн шинжилгээ хийх зорилгоор ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

“Хариуцлагатай уул уурхай-Хамтын ажиллагаа” зөвлөгөөнийг 03 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж уул уурхайн ашиглалт болон боловсруулах, баяжуулах үйлдвэр, тээврийн компанийн нийт 116 компанийн 160 гаруй төлөөлөл, сумдын Засаг дарга, Байгаль орчны мэргэжилтэн, Холбогдох төрийн байгууллагуудын 53 албан хаагч, бусад төрийн байгууллагуудын төлөөлөл нийт 220 гаруй иргэн оролцож уул уурхайн салбарт гарч байгаа зөрчил дутагдал, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар зөвлөлдлөө. Зөвлөгөөнөөр 2019 онд Хамтран ажиллах гэрээг 9 сумын 56 компанитай гэрээ байгууллаа.

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэхээр Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн 2 өргөдөлд санал авах, аймгийн “Ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөө”-г мөн хэлэлцэн батлуулах саналыг хүргүүллээ.

Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдын нэгдсэн уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулсан.

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 218 дугаар тогтоолоор тус Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, 50 тн тэжээл, сумдын нөөцөд 560 тн өвс, 420 тн тэжээл, нийт 660 тн өвс, 470 тн тэжээл бэлтгэхээс аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс, сумдын аюулгүйн нөөцөд 508.9 тн өвс, 376.3 тн тэжээл, малчдын түвшинд 4873.1 тн өвс, 376.3 тн үйлдвэрийн болон гар тэжээл 620.1 тн давс, хужир шүү бэлтгэн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг **80.2** хувьтай хангасан.

Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд хаваржилт хэвийн **4233** малчин өрхийн **2147164** толгой мал хаваржиж байна. Оны эхэнд 929078 толгой хээлтэгч тоологдсон. Үүнээс ингэ-16957, гүү-45418, үнээ-31825, эм хонь-418421, эм ямаа-416457 байна. Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд 29952 эх мал төллөж 316 ботго, 164 унага, 467 тугал, 20488 хурга, 8396 ишиг нийт 29830 төл хүлээн авч төллөлт **3.2 хувь**, төл бойжилт **99.5** хувьтай байна.

Аймгийн аюулгүйн нөөцийн өвсийг малчдад 7500 төгрөгөөр, сумд аюулгүйн нөөцийн өвсний дундаж үнэ -5500-8000, тэжээл-12000-13600 төгрөгний ханштай борлуулж байна.

Том малын зүй бусын хорогдлоор тэмээ - 8, адуу- 11, үхэр-9, хонь- 67, ямаа-97, бүгд 192 толгой мал хорогдсон байна. Үүнээс өвчнөөр тэмээ-5, адуу-2, үхэр-4, хонь-34, ямаа-32 бүгд 77 толгой мал хорогдсон.

Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэхэд улс, аймгийн хөрөнгөөр 2019 онд шинээр гаргах 25 инженерийн хийцтэй худгийн тендер зарлагдаад байна.

Хийсэн ажил: Аймгийн малын эмч, мэргэжилтнүүдийн нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг 22, 23-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалт, зөвлөгөөнд аймаг, сумдын нийт 60 гаруй эмч, мэргэжилтэн оролцлоо.

“Сум, хөгжүүлэх сан”-гаас урьд онуудад олгосон зээлийг зориулалтын бусаар ашигласан, төлөлтийн хугацаа хэтрүүлсэн зээлдэгчдийг холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэн сангийн хөрөнгийг шуурхай татан төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллах үүрэг чиглэлийг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн. Сайншанд суманд үйл ажиллагаа явуулж буй 3 фермерт мах, сүүний хосолмол ашиг шимт 30 үнээ олгуулахаар Мал хамгаалах санд хүсэлт хүргүүлсэн.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санд 4 дүгээр сарын 15-аас өмнө 2.0 тэр бум төгрөг хуваарилан орон нутагт дэмжлэг үзүүлэх хүсэлтийг ХХААХҮСайдад хүргүүлсэн

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын одоогийн үйл ажиллагаа явуулж буй барилга нь ашиглалтын шаардлага хангахгүй болсон тул шинээр барилга барих төсвийг 2020 оны улсын төсөвт тусгуулах хүсэлтийг ХХААХҮСайдад хүргүүлсэн

Зарим сумдын бэлчээрийн усан хангамж, мал угаалыг банны хүрэлцээг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд тоногт төхөөрөмж нийлүүлэх судалгааг гарган холбогдох газарт хүргүүлсэн

Хатанбулаг, Хөвсгөл сумдад шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг 14 хоногт багтаан зохион байгуулахаар шийдвэрлүүлсэн

Мал, амьтны галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх аймгийн төлөвлөгөө батлуулсан.

“Жимс, жимсгэнэ”, “Хүнсний ногоо”, “Орон нутгийн экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх” аймгийн дэд хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулсан.

ХХААХҮЯ-наас 03 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулсан ЖДҮ-ийн сургалтанд бодлогын мэргэжилтэн хамрагдсан. Дорноговь аймагт ЖДҮ-ийг хөгжүүлэх 1 тэрбум төгрөгийг хувиарласан. Төсөл сонгон шалгуурлалт зарлах журмыг 4 сард багтаан ЗГ-аас батлахаар шийдвэрлэгдсэн.

Аймгийн хэрэглэгчдийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлөөс 03 дугаар сарын 14-ны өдөр Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан.

ХХААХҮЯ-ны сайдын 2019.03.07-ны өдрийн хуралдаанаар Дэлгэрэхийн улаан ямааг омгоор баталгаажуулсан.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, худалдаа үйлчилгээний газрын төрлийг тогтооход холбогдох байгууллагуудын саналыг авч нэгтгэн ХХААХҮС-д хүргүүлсэн. Малчид, иргэдэд байгаль цаг уурын гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх, цаг үеийн мэдээ мэдээллийг шуурхай хүргэх зорилгоор Масс мессеж үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардагдах санхүүжилт 5.0 сая төгрөгийг шийдвэрлэсэн.

1.6. Хууль эрх зүйн хэлтэс:

Бодлогын ажлын хүрээнд: Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх, салбар дундын үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий дэд зөвлөлийг 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулж байгаагаас гадна аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх”, “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулан бэлтгэл ажлыг хангаж байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас Хууль эрх зүйн үндэслэл нь шинэчлэгдэн өөрчлөгдөж, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн баталж улсын бүртгэлд бүртгүүлэх, тухайн нийгмийн харилцааг зохицуулах боломжгүй болсны улмаас шинэчлэн батлах, хүчингүй болгох шаардлагатай захиргааны хэм хэмжээ тогтоосон 14 акт буюу тогтоол ирүүлснийг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулж байна.

“Эрх зүйн цахим хөтөч” сайтад байршуулах Төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг Төрийн байгууллага болон сумдаас авч нэгтгэж хүргүүлж байна.

Хууль зүйн туслалцааны төвийн Дорноговь аймаг дахь салбарын ажлын байранд орон нутгийн төсвөөс 4.5 сая төгрөгийг зарцуулан засвар, үйлчилгээ хийж дууслаа.

Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч нь 2019 оны эхний улирлын байдлаар “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийг сурталчлан 10 гаруй сургалтыг зохион байгуулж 28 иргэнд ганцаарчилсан зөвлөгөөгөөр үйлчилж, төлбөрийн чадваргүй 6 яллагдагчид үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэн, эрх ашгийг хамгаалан ажилласан байна.

Цаашид Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран аймгийн хэмжээнд 60 Эрх зүйн хөтөч бэлтгэн, эрх зүйн сургалт, сурталчилгааг иргэдийн хэрэгцээнд тулгуурлан шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулан, Хууль зүйн туслалцааны төвд ажиллах Өмгөөлөгчийн тоог нэмэгдүүлж иргэдэд хууль, эрх зүйн мэдээллийг хүртээмжтэй шуурхай хүргэхээр ажиллаж байна.

Хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалах ажлын чиглэлээр: Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан аймгийн салбар зөвлөлөөс “Хэрэглэгчээ сонсьё” өдөрлөгийн арга хэмжээг 2019 оны 03 дугаар сарын 14-ны өдөр хэрэглэгч төвтэй үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгж, зарим төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж давхардсан тоогоор 175 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.

Хэрэглэгчдийн санал хүсэлтийг хүлээн авах, ус дулаан, цахилгаан зэрэг асуудлаар ирүүлж буй гомдол, мэдээллийг түргэн шуурхай шийдвэрлэх зорилгоор Сайншанд, Замын-үүд сумдын “Нэг цонхны үйлчилгээний төв”-д “Хэрэглэгчээ сонсьё” үйлчилгээний цэгийг ажиллуулж, гомдлол, мэдээллийг 70523737 тусгай дугаар утсанд хүлээн авах ажлыг эхлүүлээд байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр: Аймгийн ИТХ-ын даргын баталсан Замын-Үүд сумын АА-н “Их замын эхэнд” бүлгийн 5 жилийн ойн арга хэмжээний сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагаанд аймгийн Мэргэжилтний баг 2019 онд зохион байгуулах ажлын талаар мэдээлэл бэлтгэн оролцлоо.

Төрийн албан хаагчийн холбогдсон эрүүгийн болон зөрчлийн хэргийн талаарх судалгааг /сүүлийн 3 жилийн байдлаар/ холбогдох байгууллагаас авч гаргасан.

Монгол Улсын галт зэвсгийн тухай хууль болон Хууль зүйн сайдын 2015 оны А/220, А/249 дүгээр тушаалаар баталсан “Галт зэвсгийн тооллого явуулах журам”, “Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн жагсаалт, түүнийг ашиглах журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор нуугдмал бүртгэлд хамрагдаагүй галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг бүртгэн авч, гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд 986 галт зэвсэгт жил бүр галт зэвсгийн тухай хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, бүртгэлжүүлсэн.

Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр: Аймгийн төрийн байгууллагуудаас 2019 онд Архивын ерөнхий газрын сургалтанд хамрагдах захиалгын дагуу 3 байгууллагын архив, бичиг хэргийн ажилтныг мэргэжил олгох, 2 байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтныг мэргэшүүлэх сургалтанд хамруулсан.

Аймаг, сумдын 8 байгууллагаас хэвлэмэл хуудасны захиалгыг хүлээн авч, Нийтлэг үйлчилгээний газарт хүргүүлэн, 6 байгууллагын 4 төрлийн хэвлэмэл хуудасны эхийг хянаж, хэвлэх зөвшөөрөл олгов.

Аймгийн Архивын тасагт 109 иргэн, 5 байгууллагын өргөдөл, хүсэлт ирүүлснийг хүлээн авч, архивын лавлагаа, тодорхойлолт 29-ыг олгож, 48 иргэнд 107 архивын баримтын хуулбар олгож үйлчилсэн.

Архивын тасгийн нөхөн бүрдүүлэлтээр төлөвлөгөөний дагуу Стандарт хэмжил зүйн газрын 2009-2013 оны байнга хадгалах 82 хадгаламжийн нэгжийг хүлээн авав.

Аймгийн Прокурорын газрын хүсэлтийн дагуу архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтанд “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын сургалт хийж, гарын авлага тараав.

Төрийн архивын дэргэдэх БНШАЗК-ын хурлыг 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдөр хуралдуулж, 4 байгууллагын 17 тоо бүртгэлийн баримт бичгийг хянан хэлэлцэж, 3 байгууллагын 12 баримт бичгийг баталж, холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

Алтанширээ сумын ЗДТГ, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2019 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хянаж, заавар зөвлөгөө өгөв.

Эрчим хүчний сайдын тушаалаар баталсан “ Эрчим хүчний барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс”-ын бүрэлдэхүүнд орж, Хөвсгөл сумын Айл баянгийн уурхайн 110 кВт-ын агаарын шугам, дэд станцыг хүлээн авах комисст Архивын тасгийн дарга ажилласан.

2017 оны архивын баримтын статистик мэдээ хоцроосон 42 төрийн байгууллагаас “Архивын баримтын бүрэлдэхүүн хөдөлгөөн, тоо хэмжээ, хадгалалтын талаархи мэдээ”-г хүлээн авч хянан, программд шивж баталгаажуулах ажил хийж байна.

Төрийн архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлтийн 2014-2018 оны судалгаа, 2008-2018 онд БНШАЗК-ын хурлаар батлагдсан төрийн байгууллагуудын данс, бүртгэлийн судалгааг гаргаж, архивын статистик мэдээ гаргах үйл ажиллагаанд ашиглаж байна.